



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, САНХҮҮ
ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛЬ**

Хөтөлбөрийн нэр: **“ЭДИЙН ЗАСАГ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР**

Индекс: D031101

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Нямаа
Гишүүд:А.Хандмаа
.....Ж.Чимгээ

Он сар өдөр: 2021-05-28

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны спортын яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
ИЗОУИС	Их Засаг Олон Улсын Их Сургууль
ИДС	Их дээд сургууль
ОУБ	Олон улсын байгууллага
СЭЗС	Санхүү эдийн засгийн сургууль
ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
ЭЗ	Эдийн засаг
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн	ИЗОУИС, Санхүү эдийн засгийн сургууль	
Хөтөлбөрийн нэр, индекс	“Эдийн засаг”	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. Н.Нямаа Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн профессорын багийн ахлагч 2. А.Хандмаа Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор, профессор 3. Ж.Чимгээ Мандах их сургуулийн профессор, доктор 	
Төлөвлөгөө	Өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2021.05.13	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2021.05.19	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2021.05.20	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2021.05.24, 25	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2021.06.03	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
	2021.06.10	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
	Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах	
Шалгуур шаардлага	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 001 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ИЗОУИС-ийн Санхүү эдийн засгийн сургуулийн “Эдийн засаг” хөтөлбөр нь 10 удаагийн төгсөлт хийж нийт 880 төгсөгчтэй. Эдгээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 87 хувь байна. 2020-2021 оны хичээлийн жилд 75 оюутан элсэн суралцаж байгаа бөгөөд тус хөтөлбөрөөр нийт 268 оюутан суралцаж байна. “Эдийн засаг” хөтөлбөрөөр суралцагч нь 127 кредит цагийн хичээлийг судалдаг.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

- Оролцогч талуудаас жил бүр авсан судалгааны тайлангууд
- Хөтөлбөрийн PEST шинжилгээ
- Олон улсын зах зээл дэх мэргэжлийн чиг хандлагын судалгаа
- Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн судалгаа
- Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын тэмдэглэлүүд

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Хөдөлмөрийн зах зээлийн болон нөхцөл байдлын шинжилгээг хийж хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээг тодорхойлсон.
- Хөтөлбөрт оролцогч талуудын саналыг жил бүр судалгаагаар авч хөтөлбөрт сайжруулалтыг хийдэг.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэхийн тулд ажлын байрны тодорхойлолт, ажлын байрны тандалт судалгааг тогтмол хийдэг.
- Хөтөлбөрийг ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй зэрэгцүүлж бусдаас ялгарах онцлогийг тодорхойлж тусгасан.
- “Цогц боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлж мэдлэг, мэргэжлийн ур чадвараас гадна зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хандлагыг төлөвшүүлдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг гадаадын нэр хүнд бүхий их сургуулиудын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан шинжилгээ хийгээгүй.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг нийтэд түгээх мэдээллийн суваг цөөн байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг гадаадын их сургуулиудын хөтөлбөртэй зэрэгцүүлсэн шинжилгээг хийх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

- “Эдийн засаг” хөтөлбөрийн баримт бичиг
- ОУИЗИС-ийн стратеги төлөвлөгөө
- Оролцогч талуудаас жил бүр авсан судалгааны тайлангууд
- Төгсөгчийн загвар

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Оролцогч талуудаас судалгаа авч эрэлт, хэрэгцээнд нийцүүлж Төгсөгчийн загварыг өөрчилж сайжруулж байна.
- Хөтөлбөрийн бусад ижил хөтөлбөрөөс ялгарах ялгаа, онцлогийг оролцогч талууд сайн ойлгосон.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайлан дээр бичигдсэн хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь байгууллагын шинжтэй бичигдсэн байгааг өөрчилж сайжруулж байгаа боловч албан ёсоор баталгаажуулах.
- Төгсөгчийн загварыг боловсруулахдаа хөтөлбөрийн давуу тал, бусдаас ялгарах онцлогийг харуулж чадаагүй, хэт товч байдлаар томъёолсон байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг сайжруулж баталгаажуулах
- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг олон нийтэд сурталчлан таниулах мэдээллийн сувгийг нэмэгдүүлэх

Шаардлага:

- Хөтөлбөрийн зорилтыг байгууллагын зорилт шиг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилго нь хөтөлбөрийн онцлогийг бүрэн гүйцэд тусгаагүй.
- Төгсөгчийн загварыг эцэслэн боловсруулж шинэчилсэн загварыг баталгаажуулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

- “Эдийн засаг” бакалаврын хөтөлбөр
- Суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагын матриц
- Оролцогч болон сонирхогч талуудаас авсан судалгааны тайлангууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график \матриц\
- Батлагдсан хичээлийн хөтөлбөрүүд

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**Давуу тал:**

- ЭЭШ-ийн дундаж оноо харьцангуй өндөртэй элсэгчид суралцдаг.
- Хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгүүд стандарт шаардлагын хүрээнд боловсруулагдсан.
- Батлагдсан хичээлүүдийн хөтөлбөрт суралцагчдад олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг тусгасан.
- Сургалтын үнэлгээний хэлбэрүүд нь хөтөлбөрийн баримт бичгүүд, хичээлийн стандарт хөтөлбөрүүдэд бүрэн тусгагдсан.
- Хөтөлбөрт оролцогч талуудаас санал авч хөтөлбөрийн үнэлгээг хийдэг.

Анхаарах асуудал:

- Оролцогч талуудаас жил бүр судалгаа авдаг ч үр дүнгээр нь хөтөлбөрийг хэрхэн сайжруулсан талаарх тайлан, мэдээг нэгтгэж гаргах
- Өөрийн үнэлгээний тайланд “сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг багтаасан” талаар хангалттай тайлбарлаж бичээгүй.

Зөвлөмж:

- Оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах, хөтөлбөрт оролцогч талуудын саналыг өргөн хүрээтэйгээр авах олон талт арга замыг эрэлхийлэх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

- “Эдийн засаг” хөтөлбөрийн баримт бичиг
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Хөтөлбөрийг шинэчилж сайжруулсан тухай хурлын тэмдэглэлүүд
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Сургалтын төлөвлөгөө
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээлүүдээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагын хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж буй байдлын матриц
- Хичээлүүдийн стандарт хөтөлбөр
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Сургалтын чанар, технологийг дээшлүүлэх зорилгоор “Эдийн засаг” хөтөлбөрт 2012, 2014, 2017, 2018 онд тус тус 4 удаа шинэчлэлт, сайжруулалтыг хийж СЭЗС-ийн хэмжээнд “Чанарын соёл”-ыг төлөвшүүлсэн.
- “Эдийн засаг” /Гааль, татварын эдийн засаг/ мэргэжлээр 2011 оноос хойш 10 жилийн хугацаанд 900 орчим оюутан төгссөн, төгсөгчдийн 87 % нь мэргэжлээрээ ажиллаж байна.
- Сургалтын ерөнхий болон явцын төлөвлөгөөг хөтөлбөрийн онцлогийг харгалзан хичээл хоорондын уялдаа холбоо, цагийн ачааллыг тооцон боловсруулж, “Хөтөлбөрийн баг” болон “Хөтөлбөрийн хороо”-гоор хэлэлцүүлж хэрэгжүүлдэг.
- Сургалтын ерөнхий төлөвлөгөө нь: ерөнхий суурь 25 хичээл – 32 кр/25%, мэргэжлийн суурь 13 хичээл - 29 кр /22%, мэргэжлийн 23 хичээл - 60 кр/48%, дадлага/курсын ажил – 7 кр/5%, - нийт: 53/127 кр/ гэсэн харьцаагаар боловсруулагдсан нь БШУС-ын А/174 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн нийтлэг шаардлагад нийцэж байна. /30% х 25% х 45%/ . Суралцагсдын “Мэдлэг-чадвар-хандлага”-ыг ижил түвшинд логик уялдаатайгаар боловсруулсан.
- Оюутан, суралцагсад хичээлийн жилд нийт 32 долоо хоног, үүнээс: I улиралд 16, II долоо хоногт 16 хоногийн хугацаатай, 7 хоногт дунджаар 18 цагийн ачаалалтай суралцдаг. Багш нарын болон оюутнуудын хамтын ажиллагаа, мэдээллийн

солилцоо, ажлын үр дүнг УМС-ийг Moodle/Xcloud программууд ашиглан, хаалттай болон нээлттэй групп чат, сүлжээгээр зохицуулдаг.

- Танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар болон бусад хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу зохион байгуулж, дадлага удирдахаар томилогдсон багш бүртгэл хөтөлж, судалгаа хийдэг.
- Оюутнууд 3 курст танилцах дадлага 14 хоног, IV курст үйлдвэрлэлийн дадлага 60 хоногийн хугацаатай гүйцэтгэж практик мэдлэгийг дээшлүүлдэг.

Анхаарах асуудал:

- Оюутны дадлагын ажлын үр өгөөжийг дээшлүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлэхэд Эдийн засгийн болон Гааль, Татварын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний нөхцөл, заалтыг боловсронгуй болгох, биелэлтийг ханган ажиллах

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд “Эдийн засаг”-ийн хичээлүүдийг нэмэх, эдийн засгийн дүн шинжилгээ хийх мэдлэг, чадварыг гүнзгий эзэмшүүлэх
- Гаалийн чиглэлийн хичээлийн сургалтын төлөвлөгөөний агуулгын зохистой харьцаа, логик харьцуулалтад судалгаа, боловсруулалт хийж, хөтөлбөрийн багаар хэлэлцэж шийдвэрлэх; Тухайлбал: “Бараа судлал” хичээлийн төлөвлөгөөний агуулгыг боловсронгуй болгож БТКУС хичээлийг нэмж оруулах
- “Гаалийн бүрдүүлэлт”, “Гаалийн татвар тариф”, Incoterms, “Гаалийн эрсдэлийн удирдлага, “Гаалийн зууч”-ийн үйл ажиллагааны талаар хичээлийн агуулга, хөтөлбөрт нэмж, стандарт хөтөлбөрийг сайжруулах

Шаардлага:

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

- “Эдийн засаг” хөтөлбөрийн баримт бичиг
- Багшийн гарын авлага
- Оюутны гарын авлага
- SWOT шинжилгээ, TOWS матриц
- Хичээлүүдийн стандарт хөтөлбөр
- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, журам
- Сургалтын арга зүйд хийсэн судалгааны тайлан

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- БШУСайдын 158 тушаал болон ИЗОУИС-иас гаргасан сургалттай холбоотой дүрэм, журам зааврыг мөрдлөг болгож, хичээлийн хөтөлбөрийн биелэлтэд ОУИС-ын сургалтын нэгдсэн албанаас нэгдсэн хяналт тавьж хэрэгжүүлдэг.
- Сургалтыг SPICES зарчимд тулгуурлан зохион байгуулж байгаа нь сургалтын үйл ажиллагаанд хийсэн SWOT шинжилгээ, TOWS матрицын дүгнэлтээр нотлогдоно.
- Сургалтыг багшлахуй, суралцахуйн идэвхтэй арга зүйг ашиглан зохион байгуулж байна. Үүнд: - Кэйсд, сорилтод, асуудалд, төсөлд суурилсан арга; - Идэвхтэй сургалтын буюу тонгоруу, багт суурилах, эвлүүлгийн аргууд; - Оюутан төвтэй: туршилт хийх, мэдлэг бүтээх, багаар ажиллах, шинжлэн судлах, асуудал

шийдвэрлэх, гадаад хэлээр харилцах, зэргээс гадна хувь хүний хандлагыг төлөвшүүлэх, сэдэлжүүлэх, сэнхрүүлэх, урам өгөх, сайшаах зэрэг зөв төлөвшилтийн аргуудыг ашигладаг.

- 2020 оны 2 сараас X cloud, Moodle, Google meet, Jitsi meet зэрэг программ ашиглаж сургалтыг зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу цахим хэлбэрээр үзүүлэх болон нээлттэй хичээлийг зохион байгуулдаг.
- Сургалт, судалгаа явуулахад шаардлагатай программ хангамж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан, сургуулийн орчинд багш, ажилчид, суралцагсад дотоод сүлжээнд холбогдон ажилладаг. Багш нарын мэдлэг, ур чадварын түвшинг 2 жил тутам аттестатчилах хэлбэрээр үнэлдэг.
- Нэгдсэн Веб хуудас, номын сангийн Фейсбүүк ашиглах боломж, оюутнууд хичээлийн бус цагаар ажиллах интернэт танхимтай.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг эсэх талаар оюутнуудаас гадна багш нараас судалгаа авч санал хүсэлтэд нийцүүлэн сайжруулдаг байх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

- “Эдийн засаг” хөтөлбөрийн баримт бичиг
- Цогц боловсрол олгох хөтөлбөр
- Хичээлүүдийн стандарт хөтөлбөр
- Сургалтад ашиглаж буй үнэлгээний арга зүйн судалгаа
- Сурлагын чанар амжилт, чанарын судалгаа
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- ИЗОУИС-ын Сургалтын нэгдсэн албанаас шалгалтын материалд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцдог. “Эдийн засаг” хөтөлбөрийн улирал бүрийн сурлагын бодит түвшин, ахиц дэвшлийг харьцуулан тодорхойлж, амжилт чанарын дүгнэлтийг хянан, нэгтгэж сургалтын нэгдсэн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгадаг.
- Суралцагсдын “Мэдлэг бүтээх” ур чадвар, хандлага төлөвшилт, суралцахуйн үр дүнг Блум-таксамоны аргаар буюу чөлөөт ярилцлага, мэтгэлцээн, тест, шинжилгээний хэлбэрээр: загвар хичээл, аман болон төсөлт хичээлийн үр дүнг Рубрикийн арга ашиглан үнэлдэг.
- Багш бүрийн зааж байгаа хичээлийн гүйцэтгэл, программын биелэлт болон амжилт чанарын үзүүлэлтийг харьцуулан үнэлж, ахиц дэвшлийг тогтоон, үр дүнгийн үнэлгээнд тусгадаг.
- 2020-2021 хичээлийн жилд I курс-75, II курс -36, III курс - 95, IV курс - 62 нийт 268 оюутан цахим орчинд вертуал хэлбэрээр суралцаж байна. Хичээлийн төгсгөлд суралцагсдаас түүврийн аргаар тусгайлан боловсруулсан асуулгын дагуу үр дүнгийн үнэлгээг үнэлж хэвшсэн.

- Суралцагсдын хүсэлтээр оноо ахиулах шалгалтыг зохион байгуулах зэрэг уян хатан зохицуулалттай. 2020\2021 оны хичээлийн жилийн II улирлын сурлагын амжилт, чанар дэвшлийн судалгаа гаргаж, харьцуулалт хийхэд, I курс-100.0/88.3, II курс-99.0/64.5, III курс 98.8/70.2 гэсэн амжилт, чанарын үнэлгээтэй дүгнэгдсэн. 2019\2020 оны хичээлийн жил буюу COVID-19 цар тахлын үед цахим орчинд сургалтаа лайв хэлбэрээр зохион байгуулж, “Эдийн засаг” хөтөлбөрийн хүрээнд 43 оюутан 100% амжилт, 92%-ын чанарын үнэлгээтэй төгссөн.
- Шалгалтын материал, даалгавар сорилын санд шинжилгээ хийх, мэдлэг шалгах тестийн санг 3 түвшинд ялгавартай боловсруулах, хичээлийг шалгалтаар болон явцаар дүгнэх байдлаар ангилж цогцоор нь журамлан, хэрэгжилтийг хангасан.
- Суралцагсдын тухайн хичээлээр эзэмшвэл зохих мэдлэг чадварын түвшинг улирал дундын, улирлын, анги дэвших, нөхөн, зөрүү, давтан оноо ахиулах, төгсөлтийн гэсэн хэлбэрээр зохион байгуулдаг. Суралцах үйл явцыг дэмжсэн, бодитой үнэлгээний жишгээр явцын, улирлын, ур чадварын, бусад гэсэн хэлбэрээр шалгалт, сорилыг зохион байгуулж, мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх журмын дагуу үнэлгээний арга зүйн кр цагийн 100 оноогоор хэрэгжүүлдэг.
- Оюутан шалгалтад бэлтгэх тогтолцоог сайжруулж, шалгалтын тест, уламжлалт шалгалтын асуултыг 14 хоногийн өмнө бэлтгэж, хөтөлбөрийн багийн хурлаар хэлэлцэж оюутнуудад тарааж бэлтгэх боломж олгосноор шалгалт, шүүлгийн ач холбогдолд эергээр нөлөөлдөг.

Анхаарах асуудал:

- Ижил чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн сайн туршлагаас суралцах

Зөвлөмж:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж буй арга зүйн өгөөж, үр нөлөөг тооцсон судалгаа, шинжилгээг нарийвчлан гүйцэтгэх
- Хөтөлбөрийн зорилго, заах арга зүй, үнэлгээний хамаарлын шинжилгээг хийх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

- Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгслийн судалгаа
- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа, оролцогч талуудтай хийсэн уулзалт

- Багшийн ажиллах орчны судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Их засаг ОУИС-ийн СЭЗС-ийн сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори нь 902 оюутны хүчин чадалтай, 838 /кв.м/ талбайтай, 8 давхар тусдаа барилгатай. “Эдийн засаг” хөтөлбөрөөр суралцагчдад хичээлийн анги, танхим, лаборатори нь 552 оюутны хүчин чадалтай, 542.5 /кв.м/ талбай ногдож байна.
- Сургалт явуулах стандарт шаардлагыг хангасан гааль, татвар, эдийн засаг зэрэг 16 мэргэжлийн кабинет, интернэтийн орчин бүхий компьютерын лаборатори, цахим хэлбэрийн номын сан, спорт заал, цайны газар 262 оюутны дотуур байр /уншлагын өрөөтэй/, багш нарын орон сууцыг тохижуулсан.
- Сургуулийн хэмжээнд утастай болон утасгүй интернэт суурилуулсан, оюутан бүртээ тулж ажиллах, сургалтаа удирдах, хянах боломж бүхий программ хангамж, сүлжээ ашигладаг.
- Оюутнууд болон төгсөгчдөөс сургалтын материаллаг бааз, орчны сэтгэл ханамжийн судалгааг ялгавартай асуумжаар зохион байгуулж үр дүнг тооцдог.
- Удирдлагын багийн гишүүд багш нарын хичээлд оролцож, заах арга зүйн талаар үнэлэлт өгч шилдэг багшийг шалгаруулж туршлагыг нь түгээн дэлгэрүүлдэг.
- Цахим хичээл боловсруулах, зохион байгуулах зориулалттай “Цахим сургалт”-ын танхимыг мэргэжлийн түвшинд техник технологиор тоноглож тохижуулсан.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Сургалт, судалгааны программ хангамжийн судалгаа
- Хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцийн судалгаа
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Хичээлийн цахим болон биет материалууд
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Багш нар хичээл, сургалтыг <https://twidp.xcloud.mn/>, <http://ikzasag.eschool.mn/>, <https://www.youtube.com/>, slide share, Google meet, Jitsi meet, /CD бичлэгүүдтэй/ зэрэг программ хангамжийг хослуулан ашиглаж, “Е-хичээл” болон сургалттай холбоотой тестийн сан, бодлого, бие даалт, шалгалтын асуулт болон лекц, семинарын word болон PPT файлаа бэлтгэн байршуулж, дүнг оруулах зэрэг оюутнуудад тухайн хичээлийг нэмж судлах мэдээлэл авах боломжийг цогцоор нь шийдвэрлэсэн. Төгсөгчид <https://www.youtube.com/>, slide share ашиглан мэдлэг, мэдээллээ дээшлүүлэх боломжтой.
- “Эдийн засаг” хөтөлбөрийн хувьд хичээлийн жилийн II улиралд tw.xcloud.mn орчинд: Лекцийн хичээлийн - 644 word файл, 644 video файл, 644 PPT, Семинарын хичээлийн - 16 word файл, 616 video файл, 616 PPT хувилбараар тус тус боловсруулан цахим орчинд байршуулан ашиглаж байна.

- Хичээлийн анги танхимд 90 компьютер, 20 гаруй проектор LCD, өсгөгч, ухаалаг индэр, канон, принтер, ТВ, зөөврийн техник хэрэгсэл, эх бэлтгэх, фотошоп программ болон оюутнууд бие даан, багаар статистик, санхүүгийн боловсруулалт хийхэд шаардлагатай программ хангамжийг суурилуулсан.
- Багш нар лимитгүй аккаунтаар олон эх сурвалж ашиглан, хичээлээ бэлтгэх боломжтой.
- ✓ Үндэсний статистикийн газраас сар бүр гардаг статистик эмхэтгэл тайлан, төрийн мэдээлэл сэтгүүл, өдөр тутмын сонин, сэтгүүл тогтмол авч, бар коджуулж, каталогид оруулдаг.

Зөвлөмж:

- Оюутнуудын эдийн засгийн судалгаа, шинжилгээнд ашиглах лицензтэй программ хангамжуудын тоог нэмэгдүүлэх. Тухайлбал: Stata, R, Vensim

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Номын сангийн ном, сурах бичгийн катологи
- Ном, сурах бичиг худалдан авахад зарцуулсан зардлын судалгаа
- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- СЭЗС-ийн Цогцолборын номын сан нь 20000 гаруй номын фондтой, нийт номын 70%-ийг мэргэжлийн ном сурах бичиг, гарын авлага эзэлж байна. “Эдийн засаг” хөтөлбөрийн мэргэжлийн сурах бичиг 465 төрөл буюу 4656 ширхэг байгаа бөгөөд нэг оюутанд 3 - 4 ширхэг ном, сурах бичиг оногдож байна. Гадаад хэл дээрх сурах бичгийн хувьд: англи хэлний 113 төрөл 1072 ш, хятад хэлний 109 төрөл 515 ш, орос хэлний 24 төрөл 862 ш, Япон хэлний 14 төрөл 605 ширхэг номын фондтой.
- Номын фондын баяжилт сүүлийн 5 жилийн байдлаар, 6.5 сая төгрөгийн өртөг бүхий 165 ш үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний судалгааны материал авч номын сангийн фондоо баяжуулсан.
- Бүх мэргэжлийн ном сурах бичгийг “Koho” программаар [http /59.153.84.140](http://59.153.84.140) хаягаар электрон каталогид оруулсан. 210 гаруй нэрийн ном сурах бичгийг PDF хувилбараар электрон хэлбэрт оруулсан.
- Электрон каталогид өдөрт суралцагсдаас 700-800 хандалт хийж, ашигладаг. Номын сангийн ашиглалт, хүртээмжийг дээшлүүлэхэд “Оюутны номын сангийн зөвлөл” хамтран ажилладаг.
- Өдөрт 100-200 уншигч танхимаар, 300-400 уншигч гэрээр ном авч үйлчлүүлдэг. Шинэ номын тойм яриа, үзэсгэлэн, танилцуулга, уулзалт тэмцээн, яруу найргийн наадам гэх мэт арга хэмжээг зохион байгуулдаг.
- Үндэсний болон УБ төв номын сан, салбар сургуулиудтай хамтран судалгаа хийж, номын солилцоо зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Эдийн засгийн чиглэлийн шинээр зохиогдсон ном, гарын авлага, сурах бичгээр баяжуулах, зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх
- Номын санд эдийн засгийн чиглэлийн цахим судалгааны ажлуудыг нэмэгдүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Их Засаг ОУИС-ийн 2009-2019, 2020-2025 оны Стратеги төлөвлөгөө
- Хөтөлбөрийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- “Эдийн засаг” мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулийн бүтэц дэх алба, хэлтсүүд идэвхтэй оролцож, сургалтын үйл ажиллагааг чанартай тасралтгүй явуулах нөөцүүдийг оновчтой хуваарилан, багшийн ажиллах орчныг бүрдүүлж, оюутны суралцах боломжоор ханган ажилладаг.
- “Эдийн засаг” мэргэжлийн хөтөлбөрийг дээд боловсрол олгох нийтлэг шаардлага, стандартын дагуу, сургуулийн эрхэм зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн чанарыг сайжруулахад удирдлагын үйл ажиллагааг чиглүүлж нийт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хуваарилалт, хүний нөөцийн бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
- Багш нар нь 3-23 жил тогтвортой ажилласан байдал нь менежментийн сайн үйл ажиллагааны үр дүн бөгөөд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бүх талаар анхаарч ажилласнаар туршлагатай, чадвартай багш нарын баг бүрдүүлж чадсан.
- Сургалтын үйл ажиллагаанд оролцож буй оюутан, төгсөгчид, ажил олгогчид, багш гээд бүх оролцогч талууд сэтгэл ханамжтай байна. Багш нарыг сурах, хөгжих боломжоор хангаж мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлдэг.
- Суралцагчдын ажиллах салбар тодорхой учир төгсөгчдийн ажлын байрны олдоц сайн.

Анхаарах асуудал:

- Суралцагч, төгсөгч, ажил олгогчдын уулзалтаас англи хэлний мэдлэгийг олгоход анхаарч, суралцах улирлыг нэмэх санал гаргасныг анхаарах

Зөвлөмж:

- Оролцогч талуудын хүсэлтэд шинжилгээ хийж англи хэлний болон ажлын байранд зайлшгүй шаардлагатай мэргэжлийн хичээлүүдийг мэргэшүүлэх хичээлд оруулах
- Бусад сургуулийн ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгааг хөтөлбөртэй уялдуулан судалж хөтөлбөрөө сайжруулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- Их Засаг ОУИС-ийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан гэрээнүүд
- Их Засаг ОУИС-ийн болон СЭЗС-ийн мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоодтой байгуулсан гэрээнүүд
- Тэтгэлэгт хамрагдсан багш, оюутны судалгаа
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**Давуу тал:**

- БНХАУ-ын хамтын ажиллагаатай сургуульд хоёр багш 100 хувийн тэтгэлэгтэй докторын зэрэг хамгаалсан.
- Оюутнууд “Супер оюутан” хөтөлбөрийн хүрээнд 1 жилийн хугацаагаар БНСУ-д 100 хувийн тэтгэлэгтэй суралцсан.
- Төрийн бус байгууллагууд, бизнесийн байгууллагуудын оюутныг дэмжих сангийн тэтгэлгээр жил бүр оюутнууд суралцдаг.
- ОХУ-ын Буриадын их сургууль, БНХАУ-ын гэрээт сургуулиудтай хамтран багш, оюутны эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Гадаадын их сургуулиудтай хамтарч хэрэгжүүлсэн ажлын үр дүн, өгөөжийг нэгтгэн дүгнэж цаашид ажиллах чиглэлийг томъёолох

Зөвлөмж:

- Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаадын их сургуулиудтай хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх, судалгааны ажилд оролцох багш нарын тоог нэмэгдүүлэх
- Гадаадын их сургуулиудтай хамтарч “хос хөтөлбөр” хэрэгжүүлэх боломжийг судлах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

- Нэг суралцагчдад ногдох өртөг, зардлын судалгаа
- Оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлтийн судалгаа, тайлан
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- “Эдийн засаг” хөтөлбөрөөр суралцагчдын төлбөр, хандивлагчдын санхүүжилтээр багш оюутны хөгжилд зориулсан танхимыг тохижуулсан, Багшийн хөгжлийн төвийг байгуулсан, сургалтын тоног төхөөрөмжөөр хангасан.
- Хөтөлбөрийн үйл ажиллагаанд зориулж жил бүр төсөв хуваарилж зарцуулалтыг Хөтөлбөрийн хороо бие даан шийдвэрлэдэг.
- “Багшийн хөгжлийн төв”-ийг мэдлэг, үр чадвараа дээшлүүлэх, суралцах бололцоогоор хангаж техник хэрэгслээр тоноглогсон.
- Оюутнууд танхимын болон үйлдвэрлэлийн дадлага хийх төсөв, бааз суурьтай.
- Оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд зарцуулах мөнгөн дүнгийн хэмжээ жил бүр нэмэгдэж 2019-2020 оны хичээлийн жилд 36.8 сая төгрөг болсон.
- Хувийн хэвшлийн байгууллагуудтай оюутны сургалт, үйлдвэрлэлийн дадлага, нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажлуудыг хамтран зохион байгуулдаг бөгөөд хандивын хэмжээ жил бүр өссөн.
- “Цогц боловсрол олгох хөтөлбөр”-т тусад нь санхүүжилтийн эх үүсвэрийг олгож хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч ажилладаг.

Анхаарах асуудал:

- Багш, оюутанд ногдох судалгаа, шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Англи хэлийг багш, оюутанд өндөр түвшинд сургах тусгай тоноглол бүхий сургалтын танхимыг байгуулах
- Судалгаа, шинжилгээний ажлаас олох орлогыг нэмэгдүүлэх

Шаардлага: /Бүрэн хангасан бол бичихгүй/**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

- Их Засаг ОУИС-ийн элсэлтийн комиссын тайлан

- Их Засаг ОУИС-ийн албан ёсны цахим хаяг
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааны тайлан
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн тайлан
- Оюутны гарын авлага

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Хөтөлбөрийн Маркетингийн зардалд зарцуулах жилээс жилд өсөж 2019-2020 оны байдлаар 50.9 сая төгрөг болсон.
- ЕБС-ийн 12-р анги төгсөгчидтэй уулзалт хийж шинэ элсэгчдэд зориулсан тэтгэлэг зарладаг.
- Боловсролын үзэсгэлэн яармагт тогтмол оролцож хөтөлбөрийн танилцуулгыг хийхээс гадна “Роял” телевизтэй тогтвортой, урт хугацааны гэрээтэй ажилладаг.
- Их Засаг ОУИС нь кино театрттайгаас гадна мэдээлэл түгээх олон сувгийг Маркетингийн идэвхжүүлэлтэд ашигладаг.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Багш, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлын амжилтыг зар сурталчилгаанд ашиглах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

- Их Засаг ОУИС-ийн албан ёсны цахим хаяг
- “Роял” телевизтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, контентууд
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вэбсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа
- Хөтөлбөрийн багш нарын сургалт, эрдэм шинжилгээ, оюутантай ажиллах ажлын төлөвлөгөө, тайлан

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Хөтөлбөрийн багийн үйл ажиллагаа болон хичээлийн стандарт, агуулгыг нээлттэйгээр сургалтын программд байршуулдаг.
- Хөтөлбөрийн ололт, амжилтыг суралцагчдын эцэг эх, ажил олгогчид үзэх боломжтойгоор байршуулж байнга сурталчилдаг.
- Хичээлүүд нээлттэй системээр явагддаг бөгөөд хөтөлбөрийн оролцогч талууд хичээлийг программаас үзэх боломжтой.
- Багш нар жил бүр үзүүлэх хичээлийг зохион байгуулж хөтөлбөр, мэргэжил, хичээлээ сурталчилдаг.
- Мэргэжлийн сурталчилгааг нийгмийн үйл ажиллагаатай холбон явуулдаг.
- Оюутнууд өөрийн үзэл бодол, санаагаа бүх төрлийн мэдээллийн суваг ашиглан хөтөлбөрийн багш, удирдлагад шууд хүргэх боломжтой.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсанд нэмж байршуулах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

- Элсэгчдэд танилцуулга хийх журам
- Оюутан элсүүлэх журам
- Элсэгчдэд мэдээлэл хийх ажлын төлөвлөгөө
- Элсэлт зохион байгуулах журам
- Элсэгчдийн ЭЕШ-ын онооны судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Элсэгчдэд олон төрлийн хөнгөлөлт үзүүлдэг. Тухайлбал, спортын амжилтаар 10-50%, урилга 10%, ЭЕШ-ын онооны хөнгөлөлт 50%, IZIU draft 60% хөнгөлөлт. Хөнгөлөлтөд олон улсын болон улсын олимпиадад эхний 1-10 дугаар байр, бүс, аймгийн хэмжээний олимпиад, уралдаанд эхний 1-10 дугаар байранд шалгарсан оюутнууд хамрагддаг. Сүүлийн 5 жилд нийт 37 оюутан сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан.
- Элсэгчдийн тоо 2019-2020 оны хичээлийн жилээс бусад жилүүдэд тасралтгүй өсөж 2020-2021 оны хичээлийн жилд 75 оюутан элссэн.
- Шинээр элссэн оюутнуудад сургуулийн захирлаас эхлээд декан, оюутан хариуцсан багш нар тусгай хуваарийн дагуу зөвлөгөө, туслалцаа үзүүлэхээс гадна чиглүүлэгч багш хариуцаж ажилладаг.
- Суралцагчид Xcloud, Moodle программаар дамжуулан мэдээ, мэдээллийг авдаг.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Олон улсын хамтарсан хөтөлбөрөөр оюутан элсүүлэх
- Хөтөлбөрөөр суралцах гадаад оюутны тоог нэмэгдүүлэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

- Цогц боловсрол олгох хөтөлбөр
- Амжилт ахиулах хөтөлбөр
- Дундчуудтай ажиллах хөтөлбөр
- Оюутантай ажиллах өдрийн удирдамж
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**Давуу тал:**

- “Цогц боловсрол олгох хөтөлбөр”, “Амжилт ахиулах хөтөлбөр”, “Дундчуудтай ажиллах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж суралцагчид суралцах, судлах арга зүйг олгох, ирээдүйн ажил мэргэжлийг нь танилцуулах, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага, хувь хүний хөгжилд анхаарч тусалдаг.
- Насанд хүрээгүй оюутнуудад зориулж чиглүүлэх үйлчилгээ, санхүүгийн дэмжих үйлчилгээ, сайн дурын ажил, нийгмийн үйлчилгээ, клуб дугуйлан зэрэг үйлчилгээнүүдийг тусгайлж үзүүлдэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад ялгаварлан гадуурхагдахгүй байх, дарамтад өртөхгүй байх, өртсөн тохиолдолд хохирлыг буруутай этгээдээс гаргуулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, анги хариуцсан багш нар сар бүр уулзаж ярилцаж хэвшсэн.
- Багш нар 7 хоногт тодорхой цагт оюутнуудтай уулзаж зөвлөгөө өгдөг.
- Хөтөлбөрийн оюутнууд Улсын чанартай 2 олимпиадад 3-р байр эзэлсэн, улсын чанартай олимпиад, уралдаан идэвхтэй оролцдог.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын эрдэм шинжилгээний ажилд зарцуулах төсөв, мөнгийг нэмэгдүүлэх, судлаач оюутан бэлтгэхэд анхаарах
- Суралцагчдад хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилт болон суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагын талаар мэдээлэл өгдөг мэдээллийн сувгийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Оюутны судлах хичээлийн болон багшийн сонголтыг нэмэгдүүлэх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны мэдээ
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээ
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- “Супер студент”, “Боловсрол-бизнес түншлэл” зэрэг олон төрлийн урамшууллыг суралцагчдад зориулдаг ба эдгээр тэтгэлэгт хамрагддаг оюутнуудын тоо харьцангуй олон.
- “Эдийн засагч” хөтөлбөрөөр суралцагчид гааль, татварын байгууллагад ажилладаг онцлогтой уялдуулж Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтод очиж танилцах аялал хийдэг нь суралцагчдыг өдөөх гол хүчин зүйл болдог.
- Оюутны уралдаан, олимпиадаас гадна спорт, урлагийн арга хэмжээнд жил бүр төсөв, төлөвлөгөө гаргаж санхүүжүүлдэг.
- Сургуулийн захиргаа, хөтөлбөрийн багш нар, оюутны клубууд суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв ажиллаж, оюутнуудыг цагийн болон үндсэн ажилд зуучлахад зориулсан олон төрлийн олон үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Суралцагчдад гадаадад цалинтай дадлага хийх боломжийг судалж, нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдын эдийн засгийн чиглэлээр гүйцэтгэх судалгааны ажлыг дэмжих, Эдийн засгийн чиглэлийн олимпиад, уралдаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх, амжилтыг дээшлүүлэх

Зөвлөмж:

- “Эдийн засаг” хөтөлбөртэй дотоодын их сургуулиудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж хамтарсан хурал, мэтгэлцээн, тэмцээн зохион байгуулж багш, оюутнууд харилцан туршлага солилцох

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

- Сургалтын албаны тайлан, мэдээ
- Сургалтын дүрэм, журмын эмхэтгэл
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцлийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Өөр сургууль рүү шилжин суралцсан оюутны тоо цөөн, харьцангуй тогтвортой суралцдаг. Сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 8 оюутан өөр сургууль рүү шилжсэн.
- Суралцагчийн шилжилтийг зохицуулж буй дүрэм, журам нь суралцагчийн эрх ашигт нийцсэн.
- “Дундчуудтай ажиллах хөтөлбөр”, “Амжилт ахиулах хөтөлбөр” хэрэгжүүлдэг нь оюутан бүртэй тулж ажиллаж сурлагаар хасагдахгүй байхад туслалцаа болдог.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Баримт нотолгоо:

- Их Засаг ОУИС-ийн диплом олгох журам
- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- БШУЯ, МХЕГ-ын шалгалтуудаар диплом бичилт, олголтын талаар ямар нэгэн зөрчил гараагүй.
- Их Засаг ОУИС-ийн диплом олгох журмын хэрэгжилт сайн.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

- Их Засаг ОУИС-д багш, ажилтан сонгон шалгаруулж авах журам
- Багш, ажилтны ажлын байрны тодорхойлолт
- Их Засаг ОУИС-ийн 2009-2019, 2020-2025 онд хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөө
- Багш, ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ
- Багш хөгжлийн дэвтэр
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Төгсөгчдөө давтан сургаж, сургалтын ажилд дадлагажуулж багш болоход нь бэлтгэдэг.
- Хөтөлбөрт мэргэжлийн 30 багш ажилладаг бөгөөд багшийн нас, ажилласан жил, туршлага, зэрэг цол тэнцвэртэй байна.
- Багш нар харьцангуй тогтвор суурьшилтай буюу 3-23 жил ажиллаж байна.

- Багшийн 30% нь доктор, профессор цолтой 13%, дэд профессор 30% эзэлдэг. Багш нар ажилдаа дуртай, сургуульдаа сэтгэл ханамжтай ажилладаг.
- Нэг багшид ногдох оюутны тоо сүүлийн 5 жилд 6-9 байгаа нь багш-оюутны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус дөхөм болсон.
- Багшийн цагийн ачаалал жилд 6-18 кр цаг байгаа ба дадлагажигч багшийн ачаалал 6 кр цаг байгаа нь сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр багшид хөгжих боломжийг бүрдүүлдэг.
- Багшийн эрдэм шинжилгээний ажлын үнэлгээ нь бодит цагаар хэмжигдэх бөгөөд үйл ажиллагаа бүрийг үнэлж хөлсийг олгодог. Багш бүр сургалт, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээс хамаарч үндсэн цалингаас гадна сар бүр урамшуулал авдаг.

Анхаарах асуудал:

- Эдийн засгийн ухаанаар докторын зэрэг хамгаалсан багшийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах
- Багш нь онол, практик хосолсон чадвартай байхад анхаарч багш нарт туслалцаа үзүүлэх

Зөвлөмж:

- Эрдэмтэн багш нар докторын диссертаци удирдах, зөвлөх багт ажиллах зэргээр эрдэмтний хувьд мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

- Их Засаг ОУИС-ийн 2009-2019, 2020-2025 онд хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөө
- Их Засаг ОУИС-ийн Багшийн албан тушаалын зэрэглэл олгох журам
- Багш, ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа
- Багш хөгжлийн дэвтэр

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг 5 жилээр боловсруулж хэрэгжүүлдэг бөгөөд “Багшийн хөгжлийн төв”-тэй, багш нар мэдлэг, чадвараа дээшлүүлэх, суралцах боломж, нөхцөлөөр хангагдсан.
- Багшийн докторантурт сурах, эрдэм шинжилгээ, мэргэжлийн чиглэлээр хөгжихөд сургалтын тэтгэлэг олгож санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.
- Сүүлийн 3 жилийн хугацаанд БНСУ, Япон, БНХАУ-ын хамтын ажиллагаатай сургуульд 8 багш суралцаж мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.
- Ахмад, залуу багш нарын залгамж холбоог хангаж харилцан бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлсэн.
- Багш нарын цалинг үе шаттай нэмэгдүүлж, сар бүр урамшуулал олгодог тогтолцоотой.
- Арилжааны банкнуудтай орон сууцны зээл, цалингийн зээл, өрхийн хэрэглээний зээл, автомашины зээл, цахилгаан барааны зээл авахад хамтран ажиллаж багш нарт тусалдаг.
- Багш нараас санал авч гадаад болон дотоодод сургалтад хамруулдаг.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрт багш нарын эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх чиглэлээр заалтуудыг түлхүү оруулах

Зөвлөмж:

- Багш нарын англи хэлний мэдлэгийг сайжруулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

- Багш нарын анкет, бүтээлийн жагсаалт, бүтээлийн үзэсгэлэн
- Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багийн төлөвлөгөө, тайлан
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Хамтын ажиллагаатай гадаад, дотоодын их сургуулиудтай хамтарч эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж багш нарыг илтгэл тавьж, өгүүлэл хэвлүүлэх боломжоор хангадаг.
- Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт эрдэм шинжилгээний ажлыг хамруулж багш нарын судалгаа, шинжилгээний ажлыг чухалчилдаг.
- Багш нарын гаргасан ном, сурах бичиг, илтгэл хэвлүүлсэн сэтгүүлүүдээр үзэсгэлэн гаргаж багш нар харилцан туршлага судлах, оюутнууд судалгааны ажлыг удирдах багшаа сонгох боломжийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Багшлах хугацаандаа хэдэн жилийн дотор доктор хамгаалах хугацааг тодорхой зааж журамд тусгах
- Их сургуульд магистраас дээш зэрэгтэй багш багшлах тул Өөрийн үнэлгээний тайлангийн хүснэгт 36-д “дотоодод магистрын зэрэг хамгаалсан багш нар” гэсэн ач холбогдолгүй хүснэгт хийснийг анхаарах.
- Багш нарын өөрийн үнэлгээний шалгуурт “бусад” гэсэн үзүүлэлт 20 хувь эзэлж байгааг анхаарч эрдэм шинжилгээний ажилд өгөх ач холбогдлыг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Докторант багш нарт докторын судалгааны ажлаа хамгаалахад түлхэц болохуйц удирдлагын болон санхүүгийн хөшүүрэг хэрэглэх
- Багш нарын олон улсын нэр хүнд бүхий, хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд нийтлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

- Багшийн ажлын аттестатчиллын журам
- Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багийн удирдамж, төлөвлөгөө, тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**Давуу тал:**

- Аттестатчиллын дүнгээр багш нарын цалинг нэмэгдүүлж, цол ахиулах тогтолцоотой. Багш нарын аттестатчиллыг 3 жил тутам хийж үр дүнд нь зэрэг дэв, цалин хангамж нэмэх, цол ахих боломжийг олгодог.
- Багшийн сургалт, эрдэм шинжилгээ болон нийгмийн үйлчилгээний цагийг ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмаар зохицуулдаг. Багш нар А, В, С цагийн гүйцэтгэлээс дараа жилийн ажлаа хэрхэн сайжруулах асуудлаа олж харж хэвшсэн.
- Багш нарын гүйцэтгэсэн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ ажил бүрийг үнэлдэг журам, тогтолцоотой.

Анхаарах асуудал:

- Хичээлийн жилийн эцэст багшийн ажлыг үнэлэхдээ аль болох олон талаас нь дүгнэх, олон түвшиний хүн оролцож үнэлэх

Зөвлөмж:

- Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд багшийн ажлыг мэргэжлийн хүн ур чадвар талаас нь, бусад оюутан, ажилчид харилцаа, хандлага, ёс зүй талаас дүгнэх боломжоор хангах 360 градус аргыг хэрэглэж турших
- Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бодит цагаар бус, кредит цаг шилжүүлэн тооцох боломжийг судлах

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын зохион байгуулалтын зураг, схем
- Хөтөлбөрийн хорооны журам
- Хөтөлбөрийн хороо байгуулах тухай захирлын тушаал
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Дотоод чанарын баталгаажуулалтын албаны төлөвлөгөө, тайлан, мэдээ
- Хөтөлбөрт оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны тайлангууд

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Их Засаг ОУИС нь байгууллагын ВАС-аар магадлан итгэмжлэгдсэн.
- Дотоод чанарын баталгаажуулалтын албатай бөгөөд уг алба нь хөтөлбөрийн хороотой хамтран хөтөлбөрийн сайжруулалтыг тасралтгүй хийдэг.
- Хөтөлбөрт оролцогч талуудын судалгааг жил бүр авч судалгааны үр дүнгээр сайжруулалтыг хийдэг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч хамт олон багаар сайн ажилладаг, эвсэг хамт олон бөгөөд хөтөлбөрийг сайжруулах хүсэл эрмэлзэлтэй.

Анхаарах асуудал:

- Багшийн үйл ажиллагаанд хяналт сайн тавьдаг ч бодлогын мониторинг, үнэлгээний ажлыг өргөжүүлэх

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох төлөвлөлтийн үе шат болон Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат гэсэн ялгаатайгаар ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг гаргах
- Хөтөлбөрт оролцогч талуудын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж үр дүнгээр нь хөтөлбөрт сайжруулалтыг хийх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Баримт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Их Засаг ОУИС-ийн чанарын баталгаажуулалтын журам
- Мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөр
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Давуу тал:

- Сүүлийн 5 жилийн дунджаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь-87%.
- Хөтөлбөрөөр төгсөгчдөд өөрийгөө бие даан хөгжүүлэх, албан хаагчийн ёс зүйг чандлан сахих тусгай сургалт явуулдаг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн карьер дээшлэлтийн судалгаа, албан тушаалын байдлын судалгааг нарийвчилж гүйцэтгэх
- Ахисан түвшинд суралцаж буй суралцагчдын судалгааг нарийвчлан гүйцэтгэх
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдсан хугацааны судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар нарийвчилж гүйцэтгэх

Зөвлөмж:

- Ахисан түвшинд сургалтад хамрагдах төгсөгчдийг татах, тэдний эрэлт, хэрэгцээг нарийвчлан судлах
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг хийх
- Мэргэжлээрээ ажиллаж буй төгсөгчдийн хувь 66.7% байгааг ахиулах

Шаардлага:

- Төгсөгчдийн карьер дээшлэлтийн байдлын судалгааг нарийвчилж боловсруулаагүй.
- Ахисан түвшинд суралцагчдын судалгааг нарийвчилж хийгээгүй, ахисан түвшинд суралцагчдын тоо цөөн.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Баримт нотолгоо:

- Гадаад, дотоодын байгууллагуудаас хүртсэн шагнал, сертификатууд
- ВАС магадлан итгэмжлүүлсэн сертификат
- Оюутан, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.
- Дотоод гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН**Давуу тал:**

- Их Засаг ОУИС нь 2014, 2017 онд Их Британийн Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл (ВАС)-аар магадлан итгэмжлүүлсэн.
- “Цогц боловсрол” хөтөлбөрийн хүрээнд амжилттай ажиллаж байгаа төгсөгчдөөрөө лекц уншуулдаг.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн холбоодтой нягт хамтран ажиллах, тэдэнтэй хэрхэн ажилласан талаарх тайлан, мэдээг гаргадаг байх
- Гадаад, дотоодын их сургуульд ахисан түвшинд суралцагчдын тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг судлах
- АНУ дахь бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэх олон улсын байгууллагаар (ACBSP) магадлан итгэмжлүүлэх зорилт тавьж ажиллах

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**ДҮГНЭЛТ**

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Нэгдсэн үнэлгээ		БҮРЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Их Засаг Олон Улсын Их Сургуулийн Санхүү эдийн засгийн сургуулийн “Эдийн засаг” хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг “ЭДИЙН ЗАСАГ” чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ИЗОУИС, СЭЗС
----------------	--------------

Хөтөлбөрийн нэр	Эдийн засаг
Хөтөлбөрийн индекс	D031101
Зөвлөмж	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийг гадаадын их сургуулиудын хөтөлбөртэй зэрэгцүүлсэн шинжилгээг хийх ➤ Хөтөлбөрийн зорилго, зорилтыг сайжруулж баталгаажуулах ➤ Хөтөлбөрийн зорилго, зорилтыг олон нийтэд сурталчлан таниулах мэдээллийн сувгийг нэмэгдүүлэх ➤ Оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах, хөтөлбөрт оролцогч талуудын саналыг өргөн хүрээтэйгээр авах олон талт арга замыг эрэлхийлэх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Сургалтын төлөвлөгөөнд “Эдийн засаг”-ийн хичээлүүдийг нэмэх, эдийн засгийн дүн шинжилгээ хийх мэдлэг, чадварыг гүнзгий эзэмшүүлэх ➤ Гаалийн чиглэлийн хичээлийн сургалтын төлөвлөгөөний агуулгын зохистой харьцаа, логик харьцуулалтад судалгаа, боловсруулалт хийж, хөтөлбөрийн багаар хэлэлцэж шийдвэрлэх; Тухайлбал: “Бараа судлал” хичээлийн төлөвлөгөөний агуулгыг боловсронгуй болгож БТКУС хичээлийг нэмж оруулах ➤ “Гаалийн бүрдүүлэлт”, “Гаалийн татвар тариф”, Incoterms, “Гаалийн эрсдэлийн удирдлага, “Гаалийн зууч”-ийн үйл ажиллагааны талаар хичээлийн агуулга, хөтөлбөрт нэмж, стандарт хөтөлбөрийг сайжруулах ➤ Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж буй арга зүйн өгөөж, үр нөлөөг тооцсон судалгаа, шинжилгээг нарийвчлан гүйцэтгэх ➤ Хөтөлбөрийн зорилго, хичээл заах арга зүй, үнэлгээний хамаарлын шинжилгээг хийх
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> ➤ Оюутнуудын эдийн засгийн судалгаа, шинжилгээнд ашиглах лицензтэй программ хангамжуудын тоог нэмэгдүүлэх. Тухайлбал: Stata, R, Vensim ➤ Эдийн засгийн чиглэлийн ном, сурах бичиг, гарын авлагыг шинээр зохиогдож гарсан ном, сурах бичгээр баяжуулах, зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх ➤ Номын сан дахь эдийн засгийн чиглэлийн цахим судалгааны ажлуудыг нэмэгдүүлэх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Оролцогч талуудын хүсэлтэд шинжилгээ хийж англи хэлний болон ажлын байранд зайлшгүй шаардлагатай мэргэжлийн хичээлүүдийг мэргэшүүлэх хичээлд оруулах ➤ Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаадын их сургуулиудтай хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх, судалгааны ажилд оролцох багш нарын тоог нэмэгдүүлэх ➤ Хамтран ажиллаж буй гадаадын их сургуулиудаас сургалт, судалгааны ажлын чиглэлээр өөрийн сургуульд сайн туршлага, ололт талыг нэвтрүүлэх ➤ Англи хэлийг багш, оюутанд өндөр түвшинд сургах тусгай тоноглол бүхий сургалтын танхимыг байгуулах ➤ Судалгаа, шинжилгээний ажлаас олох орлогыг нэмэгдүүлэх ➤ Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсанд нэмж байршуулах

Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> ➤ Олон улсын хамтарсан хөтөлбөрөөр оюутан элсүүлэх ➤ Хөтөлбөрөөр суралцах гадаад оюутны тоог нэмэгдүүлэх ➤ Оюутны судлах хичээлийн болон багшийн сонголтыг нэмэгдүүлэх ➤ “Эдийн засаг” хөтөлбөртэй дотоодын их сургуулиудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж хамтарсан хурал, мэтгэлцээн, тэмцээн зохион байгуулж багш, оюутнууд харилцан туршлага солилцох
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ Эрдэмтэн багш нар докторын диссертаци удирдах, зөвлөх багт ажиллах зэргээр эрдэмтний хувьд мэдлэг, чадвараа дээшлүүлэх ➤ Багш нарын англи хэлний мэдлэгийг сайжруулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх ➤ Докторант багш нарт докторын судалгааны ажлаа хамгаалахад түлхэц болохуйц удирдлагын болон санхүүгийн хөшүүрэг хэрэглэх ➤ Багш нарын олон улсын нэр хүнд бүхий, хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд нийтлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэх ➤ Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд 360 градус аргыг хэрэглэж турших ➤ Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бодит цагаар бус, кредит цагт шилжүүлэн тооцох боломжийг судлах
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох төлөвлөлтийн үе шат болон Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат гэсэн ялгаатайгаар ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг гаргах ➤ Хөтөлбөрт оролцогч талуудын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж үр дүнгээр нь хөтөлбөрт сайжруулалтыг хийх ➤ Ахисан түвшинд сургалтад хамрагдах төгсөгчдийг татах, тэдний эрэлт, хэрэгцээг нарийвчлан судлах ➤ Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг хийх ➤ АНУ дахь бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэх олон улсын байгууллагаар (ACBSP) магадлан итгэмжлүүлэх зорилт тавьж ажиллах
ШААРДЛАГА:	
1.2 Хөтөлбөрийн зорилго	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн зорилтыг байгууллагын зорилт шиг тодорхойлсон. ➤ Хөтөлбөрийн зорилго нь хөтөлбөрийн онцлогийг бүрэн гүйцэд тусгаагүй. ➤ Төгсөгчийн загварыг эцэслэн боловсруулж баталгаажуулах шаардлагатай.
7.2. Хөтөлбөрийн үр дүн	<ul style="list-style-type: none"> ➤ Төгсөгчдийн карьер дээшлэлтийн байдлын судалгааг нарийвчилж боловсруулаагүй. ➤ Ахисан түвшинд суралцагчдын судалгааг нарийвчилж хийгээгүй, ахисан түвшинд суралцагчдын тоо цөөн.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Н.Нямаа
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... А.Хандмаа
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Ж.Чимгээ

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
			Орон нутгийн, гадаад, Дотуур байранд амьдардаг гэх мэт

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн
дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/